

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАРТ ХОЛБОГДОХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус байгууллагад холбогдох заалтуудын 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно.

Байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй буюу үнэлгээнд оруулан тооцох боломжгүй дараах арга хэмжээг хяналтаас хасуулах саналтай байна.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна.

Үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд уг зорилтод тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Гадаадын иргэн, харьяатын газрын оролцоог тусгаагүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, хамтрагч байгууллага нь Боомтын үндэсний зөвлөл, оролцогч байгууллага нь Иргэний нисэхийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар байхаар заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 50 хувь буюу 2.5 оноотой дүгнэгдлээ.

Хэрэгжилт хангалтгүй байгаа нь “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийг хөгжүүлэхээр “Гэрэгэ системс ХХК”-тай байгуулсан гэрээний гүйцэтгэл хэт удаашралтай байснаас гэрээг цуцалж, системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэх компанийг дахин сонгон шалгаруулах шаардлага үүссэнтэй холбоотой.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.9-д “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” ажлын хэрэгжилт удааширч байгаа тул зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэн түргэн шуурхай, нягт хамтран ажиллах арга хэмжээ авч, гүйцэтгэгч талтай гэрээ байгуулж, “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” үүсгэх, хөгжүүлэх ажлыг яаралтай эхлүүлэн жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн ханган ажиллах шаардлагатай байна.

--oo0oo--